

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймгийн Дадал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХЭА-2026/014/НА-СТА-ТТЗ

Чингис хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар  
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа  
Утас: 99775390

Аудитор: Д.Эрдэнэтуяа  
Утас: 99569599

Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

|  |           |
|--|-----------|
| Аудитын гол асуудал .....  | 4         |
| <b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТЭГСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....</b> | <b>6</b>  |
| <b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....</b>  | <b>14</b> |
| 5.1 Төлбөрийн акт.....   | 16        |
| 5.2 Албан шаардлага .....  | 16        |
| 5.3 Зөвлөмж .....  | 17        |
| <b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....</b>                 | <b>18</b> |
| .....  | 18        |

---

**Товчилсон үгийн жагсаалт**

|          |  |
|----------|--|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт      |
| ОНХС     | Орон нутгийн хөгжлийн сан                          |
| СТА      | Санхүүгийн тайлангийн аудит                        |
| ТШЗ      | Төсвийн шууд захирагч                              |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын |



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН  
ГАЗАР**

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,  
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,  
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.03.25 № 506  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хэнтий аймгийн Дадал сумын Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн сумын Засаг даргын 164,716.1 мянган төгрөг, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 28,970.4 мянган төгрөг, Засаг даргын тамгын газрын 21,961.4 мянган төгрөг, Орон нутгийн хөгжлийн сангийн 6,000.0 мянган төгрөг, нийт 221,648.0 мянган төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- ✓ Тайлант онд төсвийн тодотгол 1 удаа хийсэн боловч орон нутгийн хөгжлийн сан, хоршоо хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлийг дутуу төлөвлөсөн,
- ✓ Хөрөнгийн орлого, малын тоо толгойн албан татварын орлого, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого, газрын төлбөрийн орлого, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг тус тус дутуу бүрдүүлсэн,
- ✓ Тайлант хугацаанд малын тоо толгойн албан татварын орлогыг орон нутгийн хөгжлийн санд дутуу төвлөрүүлсэн,
- ✓ Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталсан санхүүжилтийг Засаг даргын тамгын газарт илүү олгосон,

- ✓ Чандмань-2025, Манлайлагч жолооч, Би өрхийн тэргүүн, Буриад сур, Хурал цом зэрэг спортын уралдаан тэмцээний шагнал, бооцоонд батлагдсан төсвөөс зарцуулсан,
- ✓ ЗГ-ын 2021 оны 402 дугаар тогтоолын дагуу төлөвлөж батлалгүйгээр үндсэн үйл ажиллагааны зардлаас ИТХ-ын төлөөлөгч нарт томилолтын зардал олгосон,
- ✓ Бүтэц орон тооны хязгаарыг хэтрүүлж иргэний танхимын ажилтанд цалин олгосон,
- ✓ Цалингийн зардлаас тушаал шийдвэргүй болон сахилгын шийтгэлтэй албан хаагчид үр дүнгийн урамшуулал олгосон,
- ✓ Үндсэн үйл ажиллагааны зардлаас буудал, хоолны зардал, засаг даргын үйл ажиллагааны зардлаас олон нийтийн цагдаагийн урамшуулал олгосон,
- ✓ Батлагдсан орон тоогоор бүрэн ажиллаж байгаа боловч бичиг хэргийн ажилтанд цахим бүртгэл, нийгмийн бодлогын мэргэжилтэнд хэвлэл мэдээллийн асуудал хариуцуулан тус бүр сарын цалингийн 40 хувиар ажил хавсарсны нэмэгдэл олгосон,
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн "Малын гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал"-аас бусад аймаг, сумдад явсан, өөр хяналт шалгалтад зэргээр шатахуунд зарцуулсан.

Энэ нь дараах хууль тогтоомж, тушаал шийдвэрийн холбогдох заалтуудыг тус тус зөрсөн байна.

- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" , 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" , 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:" , 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" , 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах".
- ✓ Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д "төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох."
- ✓ Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "Малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна."
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.8-т "байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах"-ыг хориглоно.
- ✓ МУ-ын ЗГ-ын 2021 оны 402 дугаар тогтоолоор баталсан "Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийлэг

жишиг, зарцуулах, тайлагнах журам"-ын 2.3-т "Төлөөлөгчийн үйл ажиллагааны зардал нь төлөөлөгчийн хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зардал, сонгогчдын дунд зохион байгуулах арга хэмжээнд шаардлагатай заал, танхимын түрээсийн зардал болон шуудан, холбоо, бичиг хэрэг, албан томилолт зэрэг урсгал зардал, урамшууллын зардлаас бүрдэнэ"

- ✓ Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах",
- ✓ Хөдөлмөрийн тухай хуулийн 123.8-д "Хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулснаас хойш нэг жил өнгөрвөл ажилтныг хөдөлмөрийн сахилгын шийтгэлгүйд тооцно"
- ✓ Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д "Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь "Үндэсний зөвлөл, хороо, комисс, ажлын хэсгийн гишүүнд үндсэн ажлын цалин хөлснөөс гадуур ажлын хөлс, урамшуулал олгохыг хориглоно."
- ✓ Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн журам"-ын 4.6. "ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй", 4.6.1. "Сум, дүүргийн ОНХС-д төвлөрөх Малын тоо толгойн албан татварын орлогын хөрөнгийг энэхүү журмын 4.5-д заасан зорилгоор зарцуулна"

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,624,908.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 3,088,384.1 мянган төгрөгийг урсгал зардалд, 400,824.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар, 135,700.0 мянган төгрөгийг эргэн төлөгдөх зээлийг санхүүжүүлэхээр төлөвлөж, төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,938,206.3 мянган төгрөг буюу 81.01 хувьтай байна.

#### **Аудитын гол асуудал**

Дадал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 174,675.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрч 9,959.0 мянган төгрөгийн 1 алдааг санхүүгийн тайланд залруулж, 1,265.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 124,510.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 36,939.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

Орон нутгийн төсөвт 1,324,679.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 1,424,846.4 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 100,167.4 мянган төгрөгөөр буюу 107.5 хувиар давуулан биелүүлсэн байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

## **Бусад асуудлын хэсэг**

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, 54.5 дахь заалтын дагуу бэлтгэж ирүүлэх үүрэгтэй боловч 54.5.4 "Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/ тайланг бэлтгэж ирүүлээгүй байна. Иймд дараагийн аудитад санхүүгийн тайлангийн бүрдлийг бүрэн хангах шаардлагатай байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ж.ГАНБААТАР

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТЭГСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ****2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан****/мянган төгрөг/**

| №  | Дансны нэр, төрөл                              | Тодруулга         | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|----|--|-------------------|----------------|-----------------|
| 1  | 1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН                     |                   | 1,194,590.61   | 1,315,123.16    |
| 2  | 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ                           | 3а, 3б            | 738,223.13     | 897,285.02      |
| 3  | 1.1.3 АВЛАГА                                   | 5а, 5б, 6а,<br>6б | 280,846.50     | 150,463.60      |
| 4  | 1.1.4 УРЬДЧИЛГАА                               | 7а, 7б            | 0.0            | 10,000.00       |
| 5  | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ                           | 8а, 8б, 8в        | 175,520.98     | 257,374.54      |
| 6  | 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН                |                   | 15,564,158.34  | 17,283,728.58   |
| 7  | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ                           | 12а, 12б,<br>12в  | 15,564,158.34  | 17,283,728.58   |
| 8  | 1.2.2.02 Биет хөрөнгө                          |                   | 14,210,004.34  | 15,927,467.92   |
| 9  | 1.2.2.03 Биет бус хөрөнгө                      | 13                | 1,354,154      | 1,356,260.67    |
| 10 | 1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2                     |                   | 16,758,748.95  | 18,598,851.75   |
| 11 | 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР                             |                   | 43,317.02      | 52,591.00       |
| 12 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР                |                   | 43,317.02      | 52,591.00       |
| 13 | 2.1.1.03 Өглөг                                 |                   | 43,317.02      | 52,591.00       |
| 14 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН                   |                   | 16,715,431.93  | 18,546,260.75   |
| 15 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо              |                   | 16,715,431.93  | 18,546,260.75   |
| 16 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал       |                   | 1,471,465.97   | 1,471,465.97    |
| 17 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн                  |                   | 15,060,704.85  | 16,924,206.29   |
| 18 | 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү      |                   | 183,261.10     | 150,588.48      |
| 19 | 2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН<br>6=4+5 |                   | 16,758,748.95  | 18,598,851.75   |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/ мянган төгрөг/

| №  | Дансны нэр, төрөл  | Тодруулга | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|----|--|-----------|----------------|-----------------|
| 1  | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН                                      |           | 4,477,890.55   | 5,797,824.91    |
| 2  | 1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО   |           | 1,342,378.61   | 1,403,732.3     |
| 3  | 1.1.1.03.1 Орлогын албан татвар  |           | 1,138,383.89   | 1,227,417.34    |
| 4  | 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар                          |           | 1,138,383.89   | 1,227,417.34    |
| 5  | 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар                                      |           | 63,295.8       | 45,714.52       |
| 6  | 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж                               |           | 140,698.92     | 130,600.44      |
| 7  | 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО   | 1а, 1б    | 1,253,451.13   | 4,394,092.62    |
| 8  | 1.1.1.04.3 Тусламжийн орлого   |           | 0.0            | 1,246,095.74    |
| 9  | 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                                 |           | 1,882,060.81   | 0.0             |
| 10 | 1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                                      | 2а, 2б    | 3,343,066.8    | 3,789,971.13    |
| 11 | 1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ   |           | 3,343,066.8    | 3,789,971.13    |
| 12 | 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                             |           | 3,245,624.3    | 3,749,011.33    |
| 13 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        |           | 950,387.6      | 1,098,150.18    |
| 14 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           |           | 118,709.93     | 153,826.98      |
| 15 | 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                |           | 771,008.94     | 824,976.13      |
| 16 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал                         |           | 74,854.98      | 54,070.73       |
| 17 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал                        |           | 34,114.83      | 100,128.81      |
| 18 | 1.1.2.01.1.07 Томилгоот, зочны зардал                                  |           | 49,826.66      | 37,610          |
| 19 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж |           | 361,820.11     | 448,860.77      |
| 20 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал                          |           | 884,901.25     | 1,031,387.74    |
| 21 | 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ  |           | 97,442.5       | 40,959.8        |
| 22 | 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)                              |           | 1,134,823.74   | 2,007,853.78    |
| 23 | 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН                                  |           | 608,400.23     | 177,024.96      |
| 24 | 1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI)=(IV)-(V)                           |           | -608,400.23    | -177,024.96     |
| 25 | 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(V)                           |           | 526,423.51     | 1,830,828.82    |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

i мянган төгрөг

| №  | Дансны нэр, төрөл  | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|----|--|----------------|-----------------|
| 1  | 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН                               | 3,594,883.18   | 3,433,995.95    |
| 2  | 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО   | 1,342,378.61   | 1,403,732.3     |
| 3  | 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар  | 1,138,383.89   | 1,227,417.34    |
| 4  | 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар                                      | 63,295.8       | 45,714.52       |
| 5  | 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж                               | 140,698.92     | 130,600.44      |
| 6  | 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж                            | 32,519.65      | 20,033.71       |
| 7  | 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр  | 43,544.67      | 54,548.08       |
| 8  | 1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр                          | 64,634.61      | 56,018.65       |
| 9  | 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО   | 370,443.76     | 2,030,263.65    |
| 10 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого                                 | 370,443.76     | 440,343.62      |
| 11 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого   | 0.0            | 1,246,095.74    |
| 12 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг          | 0.0            | 343,824.3       |
| 13 | 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                                 | 1,882,060.81   | 0.0             |
| 14 | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                                | 2,577,857.64   | 2,991,999.9     |
| 15 | 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ   | 2,577,857.64   | 2,991,999.9     |
| 16 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                             | 2,480,415.14   | 2,936,830.31    |
| 17 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 1,023,050.44   | 1,225,560.83    |
| 18 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 135,032.08     | 153,826.98      |
| 19 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал                | 771,008.94     | 824,976.13      |
| 20 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал                         | 109,470.16     | 190,646.64      |
| 21 | 1.1.1.2.01.1.05 Нормативт зардал   | 1,794          | 4,807           |
| 22 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал                        | 34,105.33      | 100,664.81      |
| 23 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал                                   | 49,826.66      | 37,610          |
| 24 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 237,976.77     | 249,920.06      |
| 25 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал                          | 118,150.73     | 148,815.85      |
| 26 | 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ  | 97,442.5       | 55,169.59       |
| 27 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)                | 1,017,025.54   | 441,996.05      |
| 28 | 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН                            | 559,820.63     | 282,409.2       |
| 29 | 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ  | 559,820.63     | 282,409.2       |
| 30 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр   | 559,820.63     | 282,409.2       |
| 31 | 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)              | -559,820.63    | -282,409.2      |
| 32 | 1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ                       | 46,000         | 524.96          |
| 33 | 1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН             | -46,000        | -524.96         |
| 34 | 1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)                    | 411,204.92     | 159,061.9       |
| 35 | 1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл                     | 327,018.21     | 738,223.13      |
| 36 | 1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл                      | 738,223.13     | 897,285.02      |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан***т/мянган төгрөг*

| №  | Дансны нэр, төрөл  | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|----|--|--|-------------------------|
| 1  | 1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл                        | 16,166,000.42                          | 16,166,000.42           |
| 2  | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл                                     | 16,166,000.42                          | 16,166,000.42           |
| 3  | 1.1.1.1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                                 | 23,008                                 | 23,008                  |
| 4  | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн   | 526,423.51                             | 526,423.51              |
| 5  | 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл                            | 16,715,431.93                          | 16,715,431.93           |
| 6  | 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл                                | 16,715,431.93                          | 16,715,431.93           |
| 7  | 1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт                         | 32,672.62                              | 32,672.62               |
| 8  | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл   | 16,748,104.55                          | 16,748,104.55           |
| 9  | 1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                                       | -32,672.62                             | -32,672.62              |
| 10 | 1.7 Тайлант үеийн үр дүн   | 1,830,828.82                           | 1,830,828.82            |
| 11 | 1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 18,546,260.75                          | 18,546,260.75           |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

i мянган төгрөг

| Дансны код | Дансны нэр, төрөл  | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл    | Зөрүү          | Хувь     |
|------------|--|--------------|--------------|----------------|----------|
| 1          | 3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН  | 6,092,881.20 | 5,285,637.79 | 807,243.41     | 86.75    |
| 11         | 3.1.01.1.1 Татварын орлого   | 1,318,679.00 | 1,403,732.30 | (85,053.30)    | 106.45   |
| 110        | 3.1.01.1.1.1 Орлогын албан татвар  | 1,117,000.00 | 1,227,417.34 | (110,417.34)   | 109.89   |
| 1100       | 3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар   | 1,117,000.00 | 1,227,417.34 | (110,417.34)   | 109.89   |
| 110001     | 3.1.01.1.1.1.1.01 Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 1,000,000.00 | 1,096,016.72 | (96,016.72)    | 109.60   |
| 110002     | 3.1.01.1.1.1.1.02 Үйл ажиллагааны орлого   | 65,000.00    | 68,600.42    | (3,600.42)     | 105.54   |
| 110003     | 3.1.01.1.1.1.1.03 Хөрөнгийн орлого   | 48,000.00    | 50,745.32    | (2,745.32)     | 105.72   |
| 110004     | 3.1.01.1.1.1.1.04 Хөрөнгө борлуулсны орлого  | 4,000.00     | 12,054.88    | (8,054.88)     | 301.37   |
| 113        | 3.1.01.1.1.3 Хөрөнгийн албан татвар  | 41,460.00    | 45,714.52    | (4,254.52)     | 110.26   |
| 113001     | 3.1.01.1.1.3.1 Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар   | 5,000.00     | 10,537.83    | (5,537.83)     | 210.76   |
| 113002     | 3.1.01.1.1.3.2 Бууны албан татвар  | 1,460.00     | 1,590.00     | (130.00)       | 108.90   |
| 113004     | 3.1.01.1.1.3.4 Малд ногдуулах албан татвар   | 35,000.00    | 33,586.69    | 1,413.31       | 95.96    |
| 118        | 3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж   | 160,219.00   | 130,600.44   | 29,618.56      | 81.51    |
| 1180       | 3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж   | 24,500.00    | 20,033.71    | 4,466.30       | 81.77    |
| 118001     | 3.1.01.1.1.8.1.01 Улсын тэмдэгийн хураамж  | 4,500.00     | 3,549.01     | 950.99         | 78.87    |
| 118006     | 3.1.01.1.1.8.1.06 Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр  | 4,000.00     | 3,169.50     | 830.50         | 79.24    |
| 118009     | 3.1.01.1.1.8.1.08 Хог хаягдлын үйлчилгээний хураамж  | 16,000.00    | 13,315.20    | 2,684.80       | 83.22    |
| 1181       | 3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр   | 55,000.00    | 54,548.08    | 451.92         | 99.18    |
| 118101     | 3.1.01.1.1.8.2.01 Газрын төлбөр  | 55,000.00    | 54,548.08    | 451.92         | 99.18    |
| 1182       | 3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр   | 80,719.00    | 56,018.65    | 24,700.35      | 69.40    |
| 118201     | 3.1.01.1.1.8.3.01 Ойн нөөц ашигласны төлбөр  | 49,406.00    | 24,164.65    | 25,241.35      | 48.91    |
| 118202     | 3.1.01.1.1.8.3.02 Ан амьтны нөөц ашигласны төлбөр  | 31,313.00    | 31,854.00    | (541.00)       | 101.73   |
| 12         | 3.1.01.1.2 Татварын бус орлого   | 4,774,202.20 | 3,881,905.50 | 892,296.70     | 81.31    |
| 120        | 3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого   | 105,080.10   | 176,547.95   | (71,467.85)    | 168.01   |
| 120003     | 3.1.01.1.2.1.3 Торгуулийн орлого   | 5,000.00     | 6,524.00     | (1,524.00)     | 130.48   |
| 120004     | 3.1.01.1.2.1.4 Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/   | 99,080.10    | 155,433.88   | (56,353.78)    | 156.88   |
| 120009     | 3.1.01.1.2.1.9 Бусад орлого  | 1,000.00     | 14,590.07    | (13,590.07)    | 1,459.01 |
| 122        | 3.1.01.1.2.3 Тусламжийн орлого   | 4,325,297.80 | 3,361,533.24 | 963,764.56     | 77.72    |
| 122003     | 3.1.01.1.2.3.3 Аймаг нийслэлээс авсан татаас   | 1,201,913.70 | 1,201,913.70 | -              | 100.00   |
| 122005     | 3.1.01.1.2.3.5 Төсвөөс санхүүжих   | 3,123,384.10 | 2,159,619.54 | 963,764.56     | 69.14    |
| 123        | 3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг  | 343,824.30   | 343,824.30   | -              | 100.00   |
| 123002     | 3.1.01.1.2.4.2 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого   | 343,824.30   | 343,824.30   | -              | 100.00   |
| II         | 3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН   | 3,624,908.40 | 5,694,617.25 | (2,069,708.85) | 157.10   |
| 21         | 3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ   | 3,090,984.10 | 5,483,092.29 | (2,392,108.19) | 177.39   |
| 210        | 3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ   | 3,022,236.00 | 2,687,041.55 | 335,194.45     | 88.91    |
| 2101       | 3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил   | 1,181,193.80 | 1,098,150.18 | 83,043.62      | 92.97    |
| 210101     | 3.1.01.2.1.1.1.01 Үндсэн цалин   | 419,327.60   | 420,367.98   | (1,040.38)     | 100.25   |
| 210102     | 3.1.01.2.1.1.1.02 Нэмэгдэл   | 445,030.90   | 404,108.56   | 40,922.34      | 90.80    |
| 210103     | 3.1.01.2.1.1.1.03 Унаа хоолны хөнгөлөлт  | 48,576.00    | 39,477.76    | 9,098.24       | 81.27    |
| 210104     | 3.1.01.2.1.1.1.04 Урамшуулал   | 44,251.90    | 30,844.00    | 13,407.90      | 69.70    |

|        |                   |  |            |            |            |        |
|--------|-------------------|--|------------|------------|------------|--------|
| 210105 | 3.1.01.2.1.1.1.05 | Гэрээт ажлын хөлс  | 224,007.40 | 203,351.87 | 20,655.53  | 90.78  |
| 2102   | 3.1.01.2.1.1.2    | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл                       | 149,176.70 | 138,921.31 | 10,255.39  | 93.13  |
| 210201 | 3.1.01.2.1.1.2.01 | Тэтгэврийн даатгал   | 101,928.80 | 94,848.01  | 7,080.79   | 93.05  |
| 210202 | 3.1.01.2.1.1.2.02 | Тэтгэмжийн даатгал   | 11,812.00  | 11,235.61  | 576.39     | 95.12  |
| 210203 | 3.1.01.2.1.1.2.03 | ҮОМШӨ-ний даатгал  | 5,906.00   | 5,504.88   | 401.12     | 93.21  |
| 210204 | 3.1.01.2.1.1.2.04 | Ажилгүйдлийн даатгал   | 5,906.00   | 5,466.56   | 439.44     | 92.56  |
| 210205 | 3.1.01.2.1.1.2.05 | Эрүүл мэндийн даатгал  | 23,623.90  | 21,866.24  | 1,757.66   | 92.56  |
| 2103   | 3.1.01.2.1.1.3    | Баир ашиглалттай холбоотой тогтмол зардал                            | 969,394.00 | 824,976.13 | 144,417.87 | 85.10  |
| 210301 | 3.1.01.2.1.1.3.01 | Гэрэл, цахилгаан   | 132,988.80 | 93,131.42  | 39,857.38  | 70.03  |
| 210302 | 3.1.01.2.1.1.3.02 | Түлш, халаалт  | 726,562.80 | 678,829.20 | 47,733.60  | 93.43  |
| 210303 | 3.1.01.2.1.1.3.03 | Цэвэр, бохир ус  | 100,842.40 | 53,015.51  | 56,826.89  | 48.27  |
| 2104   | 3.1.01.2.1.1.4    | Хангамж, бараа материалын зардал                                     | 54,519.40  | 47,708.61  | 6,810.79   | 87.51  |
| 210401 | 3.1.01.2.1.1.4.01 | Бичиг хэрэг  | 6,439.40   | 5,533.50   | 905.90     | 85.93  |
| 210402 | 3.1.01.2.1.1.4.02 | Тээвэр, шатахуун   | 30,748.70  | 27,237.29  | 3,511.41   | 88.58  |
| 210403 | 3.1.01.2.1.1.4.03 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр                                   | 5,588.50   | 4,774.38   | 814.13     | 85.43  |
| 210404 | 3.1.01.2.1.1.4.04 | Нөм, хөдлөл  | 5,000.00   | 4,000.00   | 1.00       | 80.00  |
| 210405 | 3.1.01.2.1.1.4.05 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал            | 1,045.00   | 225.00     | 820.00     | 21.53  |
| 210406 | 3.1.01.2.1.1.4.06 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс                          | 5,697.80   | 4,939.45   | 758.35     | 86.69  |
| 2105   | 3.1.01.2.1.1.5    | Нормативт зардал   | 4,807.00   | 4,807.00   | -          | 100.00 |
| 210503 | 3.1.01.2.1.1.5.03 | Нормын хурцас, зөөлөн эдлэл  | 4,807.00   | 4,807.00   | -          | 100.00 |
| 2106   | 3.1.01.2.1.1.6    | Эд хогшил, урсгал засварын зардал                                    | 119,308.60 | 117,234.24 | 2,074.36   | 98.26  |
| 210601 | 3.1.01.2.1.1.6.01 | Багаж, техник, хэрэгсэл  | 15,105.80  | 15,105.20  | 0.60       | 100.00 |
| 210602 | 3.1.01.2.1.1.6.02 | Тавилга  | 5,000.00   | 5,062.00   | (62.00)    | 101.24 |
| 210603 | 3.1.01.2.1.1.6.03 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл   | 943.10     | 230.00     | 713.10     | 24.39  |
| 210604 | 3.1.01.2.1.1.6.04 | Урсгал засвар  | 98,259.70  | 96,837.04  | 1,422.66   | 98.55  |
| 2107   | 3.1.01.2.1.1.7    | Томилот, зочны зардал  | 43,639.00  | 37,610.00  | 6,029.00   | 86.18  |
| 210702 | 3.1.01.2.1.1.7.02 | Дотоод албан томилот   | 37,839.00  | 32,810.00  | 5,029.00   | 86.71  |
| 210703 | 3.1.01.2.1.1.7.03 | Зочин төлөөлөгч хүлээн авах  | 5,800.00   | 4,800.00   | 1,000.00   | 82.76  |
| 2108   | 3.1.01.2.1.1.8    | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж             | 285,067.20 | 234,490.33 | 50,576.87  | 82.26  |
| 210801 | 3.1.01.2.1.1.8.01 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 259,929.90 | 221,558.20 | 38,371.70  | 85.24  |
| 210802 | 3.1.01.2.1.1.8.02 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох                             | 961.70     | -          | 961.70     | -      |
| 210803 | 3.1.01.2.1.1.8.03 | Даатгалын үйлчилгээ  | 1,014.30   | 1,014.00   | 0.30       | 99.97  |
| 210804 | 3.1.01.2.1.1.8.04 | Тээврийн хэрэгслийн татвар   | 536.40     | 292.10     | 244.31     | 54.45  |
| 210805 | 3.1.01.2.1.1.8.05 | Тээврийн хэрэгслийн оношлогоо  | 245.60     | 121.00     | 124.60     | 49.27  |
| 210806 | 3.1.01.2.1.1.8.06 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ                                      | 1,595.40   | 1,348.00   | 247.40     | 84.49  |

|        |                   |   |                |              |                |           |
|--------|-------------------|---|----------------|--------------|----------------|-----------|
| 210807 | 3.1.01.2.1.1.8.07 | Газрын төлбөр                                       | 20,783.90      | 10,157.04    | 10,626.86      | 48.87     |
| 2109   | 3.1.01.2.1.1.9    | Бараа үйлчилгээний бусад зардал                     | 215,130.30     | 183,143.75   | 31,986.55      | 85.13     |
| 210901 | 3.1.01.2.1.1.9.01 | Бараа үйлчилгээний бусад зардал                     | 205,689.40     | 179,181.25   | 26,508.15      | 87.11     |
| 210902 | 3.1.01.2.1.1.9.02 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                   | 9,440.90       | 3,962.50     | 5,478.40       | 41.97     |
| 213    | 3.1.01.2.1.4      | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                    | 68,748.10      | 2,796,050.74 | (2,727,302.64) | 4,067.10  |
| 2131   | 3.1.01.2.1.4.1    | Засгийн газрын урсгал шилжүүлэг                     | 10,500.00      | 2,766,888.94 | (2,756,388.94) | 26,351.32 |
| 213101 | 3.1.01.2.1.4.1.01 | Засгийн газрын дотоод шилжүүлэг                     | 10,500.00      | 10,478.00    | 22.00          | 99.79     |
| 213103 | 3.1.01.2.1.4.1.03 | Төсвийн санхүүжилт                                  | -              | 2,756,410.94 | (2,756,410.94) |           |
| 2132   | 3.1.01.2.1.4.2    | Бусад урсгал шилжүүлэг                              | 58,248.10      | 29,161.80    | 29,086.30      | 50.06     |
| 213204 | 3.1.01.2.1.4.2.03 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал      | 1,500.00       | -            | 1,500.00       | -         |
| 213205 | 3.1.01.2.1.4.2.04 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал            | 25,740.00      | 25,740.00    |                | 100.00    |
| 213207 | 3.1.01.2.1.4.2.06 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 26,426.60      | -            | 26,426.60      | -         |
| 213209 | 3.1.01.2.1.4.2.08 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал             | 4,581.50       | 3,421.80     | 1,159.70       | 74.69     |
| 22     | 3.1.01.2.2        | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ                                    | 400,824.30     | 211,000.00   | 189,824.30     | 52.64     |
| 223001 | 3.1.01.2.2.4      | Бусад хөрөнгө                                       | 400,824.30     | 211,000.00   | 189,824.30     | 52.64     |
| 23     | 3.1.01.2.3        | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ          | 133,100.00     | 524.96       | 132,575.04     | 0.39      |
| 230001 | 3.1.01.2.3.1      | Эргэж төлөгдөх зээл                                 | 133,100.00     | 524.96       | 132,575.04     | 0.39      |
| 8      | 3.1.01            | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ                          | 2,467,972.80   | (408,979.46) | 2,876,952.26   | (16.57)   |
| 9      | 3.1               | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                    | (2,467,972.80) | 408,979.46   | (2,876,952.26) | (16.57)   |
| 7      | 3                 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт   | (2,467,972.80) | 408,979.46   | (2,876,952.26) | (16.57)   |
| 4      | 4                 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл    | -              | 686,939.04   |                |           |
| 5      | 5                 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл   | -              | 874,750.98   |                |           |
| 6      | 6                 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                    | 54.00          | 54.00        | -              | 100.00    |
| 61     | 6.1               | БАЙГУУЛЛАГЫН ТОО                                    | 2.00           | 2.00         | -              | 100.00    |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ мянган төгрөг/

| Дансны код | Дансны нэр, төрөл  | Тайлант он  |
|------------|--|-------------|
| 1          | 1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН   | 44,182.04   |
| 12         | 1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО  | 44,182.04   |
| 122        | 1.1.1.1.1.1 Тусламжийн орлого  | 44,182.04   |
| 1221       | 1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/  | 44,182.04   |
| 12213      | 1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого  | 44,182.04   |
| 350014     | 1.1.1.1.1.1.1.1.4 Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,000.00    |
| 350015     | 1.1.1.1.1.1.1.1.5 Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого                               | 41,182.04   |
| !!         | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН  | 30,077.85   |
| 21         | 1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ  | 30,077.85   |
| 210        | 1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ  | 29,377.85   |
| 2104       | 1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал   | 5,125.98    |
| 210402     | 1.1.1.2.1.1.4.2 Тээвэр, шатахуун   | 4,491.38    |
| 210403     | 1.1.1.2.1.1.4.3 Шуудан, холбоо, интернэтийн төлбөр   | 120.00      |
| 210406     | 1.1.1.2.1.1.4.6 Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс  | 514.60      |
| 2106       | 1.1.1.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал  | 13,011.87   |
| 210601     | 1.1.1.2.1.1.6.1 Багаж, техник, хэрэгсэл  | 9,414.60    |
| 210604     | 1.1.1.2.1.1.6.4 Урсгал засвар  | 3,597.27    |
| 2108       | 1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж   | 11,240.00   |
| 210801     | 1.1.1.2.1.1.8.1 Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж   | 11,240.00   |
| 213        | 1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 700.00      |
| 2132       | 1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг   | 700.00      |
| 213209     | 1.1.1.2.1.4.2.8 Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал  | 700.00      |
| 4          | 1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ   | 14,104.19   |
| 5          | 1.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР   | (14,104.19) |
| 6          | 1 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт  | (14,104.19) |

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Дадал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн төсвийн 2 байгууллага, 1 төрийн сан, 2 тусгай сан, 1 орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, улсын төсвийн 4 байгууллагын тогтмол зардал, нийт 10 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 4 байгууллагад санал дүгнэлт гаргаж, 6 байгууллагын санхүүгийн тайланг аудитын түүвэрт хамруулсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын тамгын газар, Ерөнхий боловсролын сургуульд аймаг дахь Төрийн аудитын газар аудит хийж “Өөрчлөлтгүй” дүгнэлт, Хүүхдийн цэцэрлэгт Ари файнэнс аудит ХХК аудит хийж “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт тус тус гаргасан байна.

#### 5.1 Тус сумын харьяа орон нутгийн болон улсын төсвийн байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн талаар:

Орон нутгийн төсвийн харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 219,827.9 мянган төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрснээс 162,896.0 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 1,353.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 55,578.7 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 6 албан шаардлага хүргүүлсэн байна.

**Аудитын илрүүлэлт:** Орон нутгийн төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

#### **Засаг даргын тамгын газар:**

- ✓ *Ахмадын хорооны барилгын засварын зураг төсвийн үнэ 10,000.0 мянган төгрөгийг шилжүүлсэн боловч урьдчилж гарсан зардалд бүртгээгүй зардалд хаасан.*  
*Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан*
- ✓ *Нэмэлт дансны үлдэгдэл 13,984.1 мянган төгрөгийг аймгийн төрийн сангаас авахаар тооцоо нийлсэн боловч санхүүгийн тайланд авлагаар тусгалагүй орхигдуулсан.*  
*Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан*
- ✓ *Зос хаан норов ХХК-аас нэхэмжилсэн 1,591.0 мянган төгрөгийн бичиг хэргийн зардлын өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан.*  
*Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан*
- ✓ *Цалингийн зардлаас 1 ажилтанд 682.2 мянган төгрөгийг тушаал шийдвэргүй, сахилгын шийтгэлтэй 2 албан хаагчид 670.9 мянган төгрөг, нийт 1,353.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал илүү олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.*  
*Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон*
- ✓ *Үндсэн үйл ажиллагааны зочин төлөөлөгч хүлээн авах зардлаас 2,244.6 мянган төгрөгийг хоол буудалд, засаг даргын мөрийн хөтөлбөрийн зардлаас 7,000.0 мянган төгрөгийг олон нийтийн цагдаагийн ажилтны урамшуулалд нийт 9,244.6 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна.*  
*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*
- ✓ *Тайлант онд бичиг хэргийн ажилтанд цахим бүртгэл, нийгмийн бодлогын мэргэжилтэнд хэвлэл мэдээлэл хариуцуулан тус бүр сарын цалингийн 40 хувиар 11,363.7 мянган төгрөгийн ажил хавсарсны нэмэгдэл олгож, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.*  
*Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.*

### Иргэдийн төлөөлөгчдийн хурал:

- ✓ Тайлант онд Чандмань-2025, Манлайлагч жолооч, Би өрхийн тэргүүн, Буриад сур, Хурал цом зэрэг спортын уралдаан тэмцээний шагнал, бооцоо, бусад зардалд 5,442.00 мянган төгрөгийг байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас зарцуулсан байна.  
Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн
- ✓ Тайлант онд үндсэн үйл ажиллагааны зардлаас ИТХ-ын төлөөлөгчдөд 5,360.00 мянган төгрөгийн албан томилолт олгож төсвийг зориулалт бус зарцуулсан байна.  
Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн
- ✓ Тайлант онд бүтэц орон тооны хязгаарыг хэтрүүлж иргэний танхимын ажилтанд 16,061.7 мянган төгрөгийн цалин олгож, 2,106.0 мянган төгрөгийн ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулсан байна.  
Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

### Орон нутгийн хөгжлийн сан:

- ✓ Сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө 2020-2035, Баян-Өндөрийн доод буланд худаг гаргах ажлуудын 107,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсан.  
Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан
- ✓ Санхүүгийн тайланд сумын малын тоо толгойн албан татварын 30,320.8 мянган төгрөгийн орлогыг тусад нь тайлагнаагүй байна..  
Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан
- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн “Малын гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны зардал”-аас бусад аймаг, сумдад явсан, өөр хяналт шалгалтад зэргээр 6,000.00 мянган төгрөгийг шатахуунд зарцуулсан байна.  
Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

Улсын төсвийн харьяа байгууллагын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,495.3 мянган төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрснээс 2,964.5 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 2,125.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 1,405.0 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 1 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитын илрүүлэлт: Улсын төсвийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

### Эрүүл мэндийн төв:

- ✓ Эмийн эргэлтийн сангийн 2,680.0 мянган төгрөгийн газрыг үнэ төлбөргүй хүлээн авснаар бүртгэж, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалыг дагуу Засгийн газрын санг нэмэгдүүлээгүй  
Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан
- ✓ Эхний үлдэгдэлтэй бичгийн цаас, хавтас гэх мэт 1,405.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг тайлант хугацаанд их хэмжээгээр худалдан авч бэлтгэсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.6 дахь заалтыг зөрчсөн байна.  
Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

### Цэцэрлэг:

- ✓ Тайлант хугацаанд 284.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материалыг аж ахуйн бараа материалын дансанд буруу бүртгэсэн.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан

- ✓ Байгууллагын дотоод журмын 31.2-т заасан хугацаанаас хэтрүүлж, тушаал шийдвэргүйгээр 9 ажилтанд 2,125.8 мянган төгрөг цалинтай чөлөө олгосон байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

- ✓ Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дээрх Засгийн газрын өмчийн дүн санхүүгийн тайлан дахь өмчийн дүн зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн

### **Дадал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл:**

Аудитаар 9,959.0 мянган төгрөгийн 1 алдаа илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залрууллаа.

- ✓ 2025 оны 12 дугаар сарын 30.31-ны өдрүүдэд арилжааны банкнаас шилжүүлсэн албан татвар, төлбөр, хураамжийн замд яваа мөнгөн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан алдааг залруулсан.

Аудитаар нийт 164,716.1 мянган төгрөгийн 4 зөрчил илэрснээс, 3,265.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 124,510.7 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 36,939.6 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

#### **5.1 Төлбөрийн акт**

- ✓ Малын тоо толгойн албан татварын 3,265.8 мянган төгрөгийн орлогыг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд дутуу төвлөрүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төлбөрийн актын биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэх

#### **5.2 Албан шаардлага**

- ✓ Сумын Засаг дарга нь орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 24,294.7 мянган төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 36,619.9 мянган төгрөгийг тус тус бүрэн төлөвлөөгүй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх," 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн

жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;", 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;" гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Албан шаардлагын биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэх

- ✓ Сумын ИТХ-аар баталсан Засаг даргын тамгын газрын санхүүжилтийг 63,596.00 мянган төгрөгөөр илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д "төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох." гэсэн заалт, нийцтэй бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Албан шаардлагын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор fas.audit.mn системд бүртгэн илгээж, аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр, нотлох баримтын хамт ирүүлэх

### **5.3 Зөвлөмж**

Илрүүлэлт: Хөрөнгийн орлогыг 2,796.7 мянган төгрөг, малын тоо толгойн албан татварын орлогыг 1,413.3 мянган төгрөг, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг 2,684.8 мянган төгрөг, газрын төлбөрийн орлогыг 4,803.4 мянган төгрөг, ойн нөөц ашигласны төлбөрийн орлогыг 25,241.3 мянган төгрөгөөр тус тус дутуу бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1: 41.2.Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ: 41.2.1.хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх; гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолоор батлагдсан орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь биелүүлж ажиллах.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дураар зүйлийн 20.5-т ".Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ." гэсэн заалтын дагуу төлөвлөгөөг 1 сарын дотор, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт албан бичгээр ирүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр               | Нийт алдаа |                   | Мэдээллийг тусгалгүй орхигдуулсан |                   | Буруу тусган илэрхийлсэн |                  | Үүнээс     |                   |              |             | Зөвлөмж  |             |
|--------------------------------|------------|-------------------|-----------------------------------|-------------------|--------------------------|------------------|------------|-------------------|--------------|-------------|----------|-------------|
|                                | Тоо        | Дүн               | Тоо                               | Дүн               | Тоо                      | Дүн              | Залруулсан |                   | Залруулаагүй |             | Тоо      | Дүн         |
|                                |            |                   |                                   |                   |                          |                  | Тоо        | Дүн               | Тоо          | Дүн         |          |             |
| Засаг дарга                    | 1          | 9,959.08          | 1                                 | 9,959.08          |                          |                  | 1          | 9,959.08          |              |             |          |             |
| ЗДТГ                           | 3          | 25,575.19         | 2                                 | 15,575.19         | 1                        | 10,000.00        | 3          | 25,575.19         |              |             |          |             |
| ОНХСан                         | 2          | 137,320.89        | 1                                 | 107,000.00        | 1                        | 30,320.89        | 2          | 137,320.89        |              |             |          |             |
| <b>ОН-ийн байгууллагын дүн</b> | <b>6</b>   | <b>172,855.16</b> | <b>4</b>                          | <b>132,534.27</b> | <b>2</b>                 | <b>40,320.89</b> | <b>6</b>   | <b>172,855.16</b> | <b>0</b>     | <b>0.00</b> | <b>0</b> | <b>0.00</b> |
| Цэцэрлэг                       | 1          | 284.50            |                                   |                   | 1                        | 284.50           | 1          | 284.50            |              |             |          |             |
| ЭМТөв                          | 1          | 2,680.00          |                                   |                   | 1                        | 2,680.00         | 1          | 2,680.00          |              |             |          |             |
| <b>УТ-ийн байгууллагын дүн</b> | <b>2</b>   | <b>2,964.50</b>   | <b>0</b>                          | <b>-</b>          | <b>2</b>                 | <b>2,964.50</b>  | <b>2</b>   | <b>2,964.50</b>   | <b>0</b>     | <b>-</b>    | <b>0</b> | <b>-</b>    |
| <b>Дүн</b>                     | <b>8</b>   | <b>175,819.66</b> | <b>4</b>                          | <b>132,534.27</b> | <b>4</b>                 | <b>43,285.39</b> | <b>8</b>   | <b>175,819.66</b> | <b>0</b>     | <b>-</b>    | <b>0</b> | <b>-</b>    |

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр               | Нийт зөрчил |                   | Төлбөрийн акт |                 | Албан шаардлага |                   | Зөвлөмж  |                  |
|--------------------------------|-------------|-------------------|---------------|-----------------|-----------------|-------------------|----------|------------------|
|                                | Тоо         | Дүн               | Тоо           | Дүн             | Тоо             | Дүн               | Тоо      | Дүн              |
| Засаг дарга                    | 4           | 164,716.13        | 1             | 3,265.80        | 2               | 124,510.71        | 1        | 36,939.62        |
| ЗДТГ                           | 3           | 21,961.46         | 1             | 1,353.15        | 2               | 20,608.31         | 0        | -                |
| ИТХ                            | 2           | 28,970.43         | 0             | -               | 2               | 28,970.43         | 0        | -                |
| ОНХСан                         | 1           | 6,000.00          | 0             | -               | 1               | 6,000.00          | 0        | -                |
| <b>ОН-ийн байгууллагын дүн</b> | <b>10</b>   | <b>221,648.02</b> | <b>2</b>      | <b>4,618.95</b> | <b>7</b>        | <b>180,089.45</b> | <b>1</b> | <b>36,939.62</b> |
| Цэцэрлэг                       | 1           | 2,125.83          | 1             | 2,125.83        | 0               | -                 | 0        | -                |
| <b>УТ-ийн байгууллагын дүн</b> | <b>1</b>    | <b>2,125.83</b>   | <b>1</b>      | <b>2,125.83</b> | <b>0</b>        | <b>-</b>          | <b>0</b> | <b>-</b>         |
| <b>Дүн</b>                     | <b>11</b>   | <b>223,773.85</b> | <b>3</b>      | <b>6,744.78</b> | <b>7</b>        | <b>180,089.45</b> | <b>1</b> | <b>36,939.62</b> |

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Байгууллагын нэр  | Нийт зөрчил |                 | Төлбөрийн акт |          | Албан шаардлага |                 | Зөвлөмж  |          |
|---|-------------|-----------------|---------------|----------|-----------------|-----------------|----------|----------|
|   | Тоо         | Дүн             | Тоо           | Дүн      | Тоо             | Дүн             | Тоо      | Дүн      |
| <b>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b> |             |                 |               |          |                 |                 |          |          |
| <b>Дүн</b>  | <b>0</b>    | <b>-</b>        | <b>0</b>      | <b>-</b> | <b>0</b>        | <b>-</b>        | <b>0</b> | <b>-</b> |
| <b>Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</b>    |             |                 |               |          |                 |                 |          |          |
|   | 0           | -               | 0             | -        | 0               | -               | 0        | -        |
| <b>ОН-ийн байгууллагын дүн</b>                                  | <b>0</b>    | <b>-</b>        | <b>0</b>      | <b>-</b> | <b>0</b>        | <b>-</b>        | <b>0</b> | <b>-</b> |
| ЭМТөв   |             |                 |               |          | 1               | 1,405.00        |          |          |
| <b>УТ-ийн байгууллагын дүн</b>                                  | <b>1</b>    | <b>1,405.00</b> | <b>0</b>      | <b>-</b> | <b>1</b>        | <b>1,405.00</b> | <b>0</b> | <b>-</b> |
| <b>Нийт дүн</b>   | <b>1</b>    | <b>1,405.00</b> | <b>0</b>      | <b>-</b> | <b>1</b>        | <b>1,405.00</b> | <b>0</b> | <b>-</b> |



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 87-А2371125  
ХЭА-2026/014/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Малын тоо толгойн албан татварын орлогын 3,265,800.00 (гурван сая хоёр зуун жаран таван мянга найман зуун) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн дансанд дутуу төвлөрүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.8-д "малын тоо толгойн албан татварын орлого. Уг орлогын эх үүсвэрийг бэлчээрийн даац тогтоох, бэлчээрийн төлөв байдлын үнэлгээ хийх, бэлчээр ашиглуулах гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах, газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаас хамгаалах, хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх, малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.4-д "төсөвт төвлөрүүлэх ёстой татварын болон татварын бус төсвийн орлогыг төсөвт дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй." гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Малын тоо толгойн албан татварын 3,265,800.00 (гурван сая хоёр зуун жаран таван мянга найман зуун) төгрөгийг Төрийн сан банк дахь ерөнхий орлогын 100181200910 тоот данснаас "Орон нутгийн хөгжлийн сан"-ийн 100181252400 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг сумын Засаг дарга Ш.Мөнххуяг-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР

Ж.ГАНБААТАР  
Д.ЭРДЭНЭТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 276 - А 2371125  
ХЭА-2026/014/НА-СТА-ТТЗ

Чингис хот

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын ИТХ-аар баталсан Засаг даргын тамгын газрын санхүүжилтийг 63,596,000.00 (жаран гурван сая таван зуун ерэн зургаан мянган) төгрөгөөр илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.8-д "төсвийн сар, улирлын хуваарьт үндэслэн төсвийн байгууллагын бүртгэлийн дансанд санхүүжилтийн болон зарцуулалтын эрх олгох." гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Санхүүжилтийг батлагдсан төсвийн хуваарийн дагуу олгодоггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Ш.Мөнххуяг-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР



Ж.ГАНБААТАР  
Д.ЭРДЭНЭТУЯА



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25

Дугаар 275-А/237/125

Чингис хот

ХЭА-2026/014/НА-СТА-ТТЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Дадал сумын Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг дарга нь орон нутгийн хөгжлийн сангийн урьд оны үлдэгдлээс 24,294,785.00 (хорин дөрвөн сая хоёр зуун ерэн дөрвөн мянга долоон зуун наян таван) төгрөг, хоршоо хөгжүүлэх сангийн үлдэгдэл 36,619,923.00 (гучин зургаан сая зургаан зуун арван есөн мянга есөн зуун хорин гурван) төгрөгийг тус тус бүрэн төлөвлөөгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх;" 6.2.3-т "урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, эсхүл зарлага нэмэгдсэнээр төсвийн алдагдал нэмэгдэхээр бол төсвийн зарлагыг бууруулах, эсхүл орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар тухайн жилийн төсөвт тодотгол хийж, төсвийг тэнцвэржүүлэх;" 6.4.-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:" 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 14.2.4-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг үндэслэлтэй төлөвлөдөггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Засаг дарга Ш.Мөнххуяг-д даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Ж.ГАНБААТАР

Д.ЭРДЭНЭТУЯА